



## **Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл**

# **ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН**

**МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль**

**Хөтөлбөр: Багш, нийгмийн ухааны боловсрол  
Багш, түүхийн боловсрол**

**Индекс: 011403**

**Шинжээчийн баг:**

**Ахлагч: Ш.Ганхуяг**

**Гишүүд: С.Цолмон  
Г.Жаргалсайхан**

2020.06.08

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1-А: Багш, нийгмийн ухааны боловсролын хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур1-Б: Багш, түүхийн боловсролын хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургууль /Монгол, Англи/</b>	МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль School of Humanities and Social Sciences of MSUE	
<b>Хөтөлбөр /Монгол, Англи/</b>	Багш, нийгмийн ухааны боловсролын Teacher of Social Science Education Багш, Түүхийн боловсролын Teacher of History Education	
<b>Индекс</b>	D 011403	
<b>Шинжээчид</b>	Ш.Ганхуяг	ШУА-ийн ФСЭХ-ийн Философийн салбарын эрхлэгч
	С.Цолмон	УБИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал
	Г.Жаргалсайхан	ОТИС-ийн Сэтгүүл зүй, олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч
<b>БМИУЗ-ийн Мэргэжилтэн</b>	Ж.Тунгалаг	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Огноо</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	2019.05.19	Шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилгүй эсэхийг баталгаажуулах
	2019.05.25	Шинжээчдийн багийн томилж, гэрээ байгуулан, өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх
	2019.05.29	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2019.06.02	Мэргэжилтэн, шинжээчийн багийн ахлагч сургуульд очиж бэлтгэл хангуулах
	2019.06.03, 04	Шинжээчид сургуульд очиж ажиллах
	2019.06.08	Шинжээчид үнэлгээний тайлан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2019.06.09	Шинжээчийн үнэлгээний тайланг сургуульд илгээж, санал авна
	2019.06.10	Сургууль санал, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.06.12	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд шинжээчийн үнэлгээний тайланг хэлэлцүүлнэ.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг баримтлав.	

## II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1. БАГШ, НИЙГМИЙН УХААНЫ БОЛОВСРОЛЫН

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж	МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Түүхийн тэнхим				
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо	1988.9.1				
Хөтөлбөрийн (одоогийн) нэр	Түүх, Нийгмийн ухааны багш				
Хөтөлбөрийн индекс	D 011403				
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа	№ 980016. 2019.6.13 5 жил				
Сургалтын хэлбэр	Өдөр				
Суралцах хугацаа	4 жил				
Сургалт явуулдаг хэл	Монгол				
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)	2011.12.22, Гэрчилгээ № 83				
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:	2019.11.6				
Багшлах бүрэлдэхүүний тоо: Үүнээс:	16				
Боловсролын зэрэг	Доктор	14			
	Магистр	3			
Албан тушаалын зэрэглэл	Профессор	4			
	Дэд профессор	4			
	Ахлах багш	4			
	Багш	4			
	Дагалдагч багш	-			
Ажлын туршлага	20-оос дээш жил	6			
	11-20	6			
	6-10 жил	3			
	5 хүртэлх жил	1			
Суралцагчдын нийт тоо	2020	2019	2018	2017	2016
	144	94	-	-	-
Үүнээс	4-р курс	-	-	-	-
	3-р курс	36	-	-	-
	2-р курс	45	43	-	-
	1-р курс	104	51	45	-
Төгсөгчдийн тоо	-	-	-	-	-
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг	МУБИС. I байр. НХУС. 310 тоот. Түүхийн тэнхим				
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох хаяг, дугаар	Түүхийн тэнхимийн эрхлэгч Ж.Гэрэлбадрах. 99142973 gerelbadrakh@msue.edu.mn				
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:	Хоёр дахь удаа				

## 2. БАГШ, ТҮҮХИЙН БОЛОВСРОЛЫН

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж	МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Түүхийн тэнхим					
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо	1951.9.1					
Хөтөлбөрийн (одоогийн) нэр	Түүхийн багш					
Хөтөлбөрийн индекс	D 011403					
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа	№ 980016. 2019.6.13 5 жил					
Сургалтын хэлбэр	Өдөр					
Суралцах хугацаа	4 жил					
Сургалт явуулдаг хэл	Монгол					
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)	2013.10.9, Гэрчилгээ № 145					
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:	2019.11.6					
Багшлах бүрэлдэхүүний тоо: Үүнээс:	16					
Боловсролын зэрэг	Доктор	13				
	Магистр	3				
Албан тушаалын зэрэглэл	Профессор	4				
	Дэд профессор	4				
	Ахлах багш	4				
	Багш	4				
Ажлын туршлага	Дагалдагч багш	-				
	20-оос дээш жил	6				
	11-20	6				
	6-10 жил	3				
	5 хүртэлх жил	1				
Суралцагчдын нийт тоо	2020	2019	2018	2017	2016	
	105	134	139	154	132	
Үүнээс	4-р курс	37	31	26	31	25
	3-р курс	35	39	29	33	26
	2-р курс	32	31	43	39	35
	1-р курс	-	33	41	51	46
Төгсөгчдийн тоо	37	31	26	31	25	
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг	МУБИС. I байр. НХУС. 310 тоот. Түүхийн тэнхим					
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох хаяг, дугаар	Түүхийн тэнхимийн эрхлэгч Ж.Гэрэлбадрах. 99142973 gerelbadrakh@msue.edu.mn					
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:	Хоёр дахь удаа					

### III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

**Шалгуур 1-А. БАГШ, НИЙГМИЙН УХААНЫ БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ**  
Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

*Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.*

#### Баримт нотолгоо:

- Ажлын төлөвлөгөө
- Хичээлийн хөтөлбөр

#### Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: 1990-ээд оноос хойш нийгмийн өөрчлөлттэй уялдуулан сургалтын хөтөлбөрөө зохицуулж хөрвөх чадвартайгаар багшлах боловсон хүчнийг бэлтгэж чадсан байна. Англи, АНУ, Сингапур, Финлянд зэрэг улсуудын тухайн чиглэлийн хөтөлбөрийг харьцуулан дүгнэлт хийхийн зэрэгцээ өөрийн онцлогтойгоор хөгжүүлж байна.

Хичээлийн хөтөлбөр боловсруулахдаа шат шатны хэсэг, хороонуудаар хэлэлцүүлж ажил олгогч нар, төгсөгчид, суралцагсдын саналыг тусгасан байсан.

Сул тал: 1992 оноос нийгмийн ухааны багш, 2000 оноос философи, улс төр судлалын багш, нийгэм судлал-эрх зүйн багш (10 жил), 2014-2015 оноос Багш, нийгмийн ухааны боловсролын хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн зэргээс харахад хөтөлбөрийн тогтвортой байдал алдагдсан.

**Дүгнэлт:** 1.1 Олон жил НУБ бэлтгэх туршлагатай (явцын дунд мөрийн хөтөлбөрүүд өөрчлөгдсөн ч гэсэн), багшлах боловсон хүчний бүрэлдэхүүн сайтай, сургалтын материаллаг баз (анги танхим, лаборатори, номын сан, оюутны бие даах төв) хангалттай зэрэг үндэслэлээр **шаардлагыг бүрэн хангасан** гэж үзэж байна.

#### 1.2 Хөтөлбөрийн зорилго

*Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.*

#### Баримт нотолгоо:

- Нэгж хичээлийн хөтөлбөрүүд
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг

#### Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Сургуулийн эрхэм зорилго, багш бэлтгэх бодлого, бусад эрх зүйн баримт бичиг ба хөтөлбөрийн зорилго хоорондын уялдаа холбоо сайн байна. 2014 оноос сургалтын чанарын шинэчлэл, бүтцийн өөрчлөлт, дэлхийн технологийн дэвшилтэй холбуулан сургалт удирдлагын үйл ажиллагааг дэмжих үүднээс удирдлага мэдээллийн систем нэвтрүүлэн ажиллаж байгаа нь сайшаалтай.

Сул тал: Мэргэжлийн болоод багшлах талын хичээлийн хоорондын харьцааны тухай асуудлыг дахин авч хэлэлцэх шаардлагатай.

**Дүгнэлт:** 1.2 Хөтөлбөрийн зорилгын давуу талыг харгалзан **шаардлагыг бүрэн хангасан** гэж дүгнэлээ.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

*Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.*

#### **Баримт нотолгоо:**

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө
- Хичээлийн хөтөлбөр

#### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: 9 зүйлийн бодлогын баримт бичгүүд дээр (МУ-ын дээд боловсролын стандарт: ЕБС-ийн багш мэргэжлийн чиглэл Стандарт 1. УБ., 2009, МУ-ын ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, XXI зууны багшийн загвар. УБ., 2014 г.м) тулгуурласан бодлого барьсан. Багш бүр нь сургалт, эрдэм шинжилгээний ажлаа 3 жилээр төлөвлөдөг. Цаг хугацааны явцад хичээлийн хөтөлбөрүүд өөрчлөгдөж байсан агуулга нь, ач холбогдлоо алдаагүй хөрвөх чадвар нь хадгалагдсаар ирсэн.

Сул тал: Хөтөлбөрөө харьцуулахдаа “Идэр” сургуулийн НУБ, “Газарчин” ДС-ийн Нийгэм судлал-эрх зүйн багшийн хөтөлбөртэй харьцуулсан байна.

НХУС-д элсэгчдийн дотор БНУБ-ын оюутны эзлэх хувь буурах хандлагатай байна (хуудас-11).

**Дүгнэлт:** 1.3 **шаардлагыг бүрэн хангасан** гэж үзлээ.

#### **ШАЛГУУР 1-А. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:**

Хөтөлбөрийг БСШУ-ны сайдын 2014 оны А/174 тушаалаар баталсан бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын дагуу боловсруулжээ. Хөтөлбөрөө шинэчлэхдээ сургалт, судалгааны байгууллагуудын төлөөлөлтэй санал солилцох, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийн санал зөвлөмжийг тусгах, оюутны төлөөллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэх мэт ажлуудыг хэрэгжүүлдэг байна. Түүнчлэн хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ улирал тутамд суралцагчаас 11 үзүүлэлтээр сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг нь хөтөлбөрийн чанарт сайнаар нөлөөлсөн байна.

**Шинжээчийн дүгнэлт:** “Багш, нийгмийн ухааны боловсролын хөтөлбөрийн төлөвлөлт” нь нийгмийн хэрэгцээ шаардлага, МУБИС-ийн эрхэм зорилгод нийцсэн төдийгүй БСШУСЯ-ны сайдын тушаалын шалгуурын дагуу боловсруулсан гэж үзээд шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН гэж шинжээчид дүгнэлээ.

#### **Зөвлөмж:**

- Хичээлийн хөтөлбөртэй холбоотой засаж сайжруулах зүйлсийг (тухайлбал хөтөлбөрийн тогтвортой байдал, алсын хараа) анхаарч, цаашид хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Хичээлийн хөтөлбөрийг зах зээлийн (хэрэглэгчийн) судалгаанд суурилан тэдний хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад тулгуурлан сайжруулахаас гадна ажил олгогч мэргэжилтнээс юуг, ямар чадварыг шаардаж байгааг олж илрүүлэн хөтөлбөртөө тусгах нь хичээлийн хөтөлбөрийн чанарын тогтворжилтонд чухал нөлөөтэй.
- Багшлах талын хичээлүүдийг интеграцлах, мэргэжлийн онолын хичээлүүдийн цагийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.
- Боловсрол судлал, сэтгэл судлалын хичээлүүдийн давхцал маш их байдгийг төгсөгчид, суралцагсад ярьж байсныг хичээлийн хөтөлбөртөө тусгах хэрэгтэй.

## Шалгуур 1-Б. БАГШ, ТҮҮХИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

*Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.*

#### Баримт нотолгоо:

- Хичээлийн хөтөлбөр
- Ажлын төлөвлөгөө
- Багш нарын бичиж нийтлүүлсэн бүтээл

#### Шинжээчийн үнэлгээ:

**Давуу тал:** Москвагийн Багшийн их сургуулийн “Түүх, нийгмийн ухааны багш”-ийн хөтөлбөртэй харьцуулалт хийсэн. ЕБС-ийн түүхийн багш нарын 70% нь МУБИС-ийг төгсчээ. Түүнчлэн нийгмийн эрэлт хэрэгцээнд суурилсан, төгсөгчдөө ажлын байраар хангах үүднээс ЕБС-иудтай гэрээ байгуулан хамтран ажилладаг, хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг олон орны ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан, гадаад хамтын ажиллагаа сайтай зэргийг дурьдаж болохоор байна.

**Сул тал:** 5-6 жилд хичээлийн хөтөлбөрөө байнга өөрчилж ирсэн байна. Энэ хичээлийн чанар үр дүнг тооцоолсон шийдвэр авч богино хугацаанд олон дахин өөрчилж байгаа нь хөтөлбөрийн үр дүнг тодорхойлход, давуу болон сул талыг тооцоход учир дутагдалтай байна.

**Дүгнэлт:** 1.1 Дээрх давуу талуудыг харгалзан үзээд шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэж байна.

### 1.2 Хөтөлбөрийн зорилго

*Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.*

#### Баримт нотолгоо:

- Түүх багшийн ангид ордог мэргэжлийн хичээлүүдийн хөтөлбөр
- Мэргэжлийн бус ангид ордог “Монголын түүх” хичээлийн хөтөлбөр

#### Шинжээчийн үнэлгээ:

**Давуу тал:** Түүх, багшийн ангид ордог ерөнхий эрдмийн, мэргэжлийн суурь, хичээлийн хөтөлбөрүүдийг сургалтын төлөвлөгөөний дагуу судалж байгаа нь агуулга болоод хэлбэрийн хувьд сайн болжээ. Түүнчлэн хөтөлбөрийн зорилгоо тодорхойлохдоо үнэт зүйлсэд тулгуурласан чадамж, хувь хүний суурь чадамж, багш боловсролын суурь чадамж, мэргэжлийн суурь чадамж гэсэн 4 үндсэн чадамжид тулгуурлан боловсруулсан нь сайшаалтай.

**Сул тал:** Мэргэжлийн бус ангиудад ордог “Монголын түүх” хичээлийг ЕБС-д үздэг хичээлийн агуулга, чанараас ахисан, дэвшилттэй зүйл алга байна. Судалсан зүйлээ дахиж судлах хандлагатай байна. Оюутнууд ч энэ тал дээр санал хүсэлтээ илэрхийлдэг.

**Дүгнэлт:** 1.2 Хөтөлбөрийг боловсруулахдаа нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж монголдоо төдийгүй гадаадын олон орны мэргэжлийн ижил хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийж



хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон зэргийг харгалзан үзээд шаардлагыг *бүрэн хангасан* гэж дүгнэж байна.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

*Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.*

#### **Баримт нотолгоо:**

- Тайлан дээр дурдагдсан баримт бичгүүдийн эх хувилбар

#### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/, XXI зууны багшийн загвар 2014, МУБИС-ийн хөгжлийн бодлого /2014-2024/, МУБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг иш болгосон, Мэргэжлийн олон байгууллага, хүрээлэнгүүдтэй хамтран ажилладаг юм байна. Хөтөлбөрийн шинэчлэлтийг хийхдээ сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж олон орны ижил хөтөлбөрүүдтэй харьцуулсан.

Сул тал: 2014 онд “Түүх, нийгэм судлалын багш”-ийн ангийн хөтөлбөрийг хааж, Түүх, нийгмийн ухааны хавсарсан хөтөлбөрийг хэрэгжүүлсэн, 2018-2011 оноос Багш, Түүх, Нийгмийн ухааны хөтөлбөрийг дахин сэргээсэн зэргээр хөтөлбөрийн тогтвортой байдал алдагдсан.

**Дүгнэлт:** 1.3 Хөтөлбөрийг төрийн бодлого, сайдын тушаал болон бусад холбогдох баримт бичгүүдийн шаардлагын дагуу боловсруулдаг төдийгүй олон улсын хөтөлбөрүүдтэй ялангуяа Москвагийн багшийн сургуулийн хөтөлбөртэй харьцуулсан нь нэн дэвшилттэй юм. Энэ бүхнийг харгалзан үзээд шаардлагыг *бүрэн хангасан* гэж дүгнэлээ.

#### **ШАЛГУУР 1-Б. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:**

Хөтөлбөрийг БСШУ-ны сайдын 2014 оны А/174 тушаалаар баталсан бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын дагуу боловсруулжээ. Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан оролцогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагджээ.

**Шинжээчийн дүгнэлт:** Шинжээчийн дүгнэлтэнд тулгуурлан “Багш, түүхийн боловсролын хөтөлбөрийн төлөвлөлт” шалгуурыг *БҮРЭН ХАНГАСАН* гэж шинжээчид дүгнэлээ.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хорооны хэлэлцүүлэгт ажил олгогч, төгсөгчдийг оролцуулахыг ажил хэрэг болгох. Ингэснээр төгсөгчдийн чанар, хөтөлбөрийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

#### **Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

## **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

### **Баримт нотолгоо:**

- Сургалтын батлагдсан төлөвлөгөө
- Мэргэжилтний загвар-хөтөлбөрийн хүрэх үр дүн

### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд суурилж, сургалтын агуулгыг үр дүнд суурилсан маягаар шинэчлэн төлөвлөсөн. Суралцагч хичээл, багш, кредит, хугацаа зэргийг өөрийн боломж нөхцөлд нийцүүлэн сонгох өргөн боломжтой. Мөн дан түүх, нийгэм судлал, түүх-нийгэм судлалын хавсарга хөтөлбөр, өөр мэргэжлээр төгссөн бол багш мэргэжлээр хөрвөн суралцах олон сонголт, олон хувилбарт хөтөлбөрийг боловсруулан дэвшүүлсэн нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангасан сайн талтай байна.

Хөтөлбөрөөр олгох онол, практикийн харьцааг хангахдаа практик чадвар, бие даан суралцахад илүү чиглэсэн. Дадлагыг танилцах 1 кр, судлах 2 кр, туршин заах 5 кр, багшлах 5 кр цагаар төлөвлөж, урт хугацаагаар, олон давтамжтай, цалинтай, хээрийн шинжилгээний гэх мэт хэлбэр төрлөөр хийдэг нь оюутны танхимаар эзэмшсэн мэдлэгийг турших, дадлагажих боломжийг олгож байгаагийн зэрэгцээ мэргэшсэн зөвлөх багш удирддаг нь онцлог давуу талтай байна.

Сул тал: Хөтөлбөрийг богино хугацаанд олон удаа бүрэн шинэчилсэн. Тайлангийн хугацаанд 2 удаа бүрэн шинэчилсэн байна. Энэ нь хөтөлбөрийн үр дүн, давуу сул талыг тогтоох, тооцох боломжгүй болгосон. Суралцагчийн цагийн ачаалал, бие даалтын цаг нэлээд их. Тухайлбал, лекц, семинар, лаборатори, практик хичээлийн цаг 2416, бие даалтын цаг 2320, нийт 4731 цаг байна.

**Дүгнэлт:** 2.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Баримт нотолгоо:**

- ТБ хөтөлбөрийн тайлангийн 30-р тал
- Оюутантай хийсэн уулзалтын мэдээлэл
- Нэгж хичээлийн хөтөлбөрүүд

### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Багш нар голлон хэрэглэдэг “хувийн” арга зүйтэй болсон байна. Тухайлбал: багш С.Энхжин “эх сурвалжид тайлбар хийх”, М.Шолпан “Оюутны бүтээл” үзэсгэлэн гаргах, Ц.Баасандорж “асуудал дэвшүүлэн шийдвэрлэх”, На.Сүхбаатар “шавь төвт арга” аар голлон зааж, үр дүнд хүрч байгааг оюутнууд ч тэмдэглэж байна. Сургалтын дээрх мэт арга зүй оюутны суралцахуйг дэмжих, хөтлөхөд чиглэсэн байна. Хоёр хөтөлбөрт хичээл заагч багш нар оюутнаар мэдлэг бүтээлгэх, бие даан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга зүйг голлож байна. Тухайлбал, эх сурвалжид тайлбар хийх, хэлэлцүүлэг хийх, тохиолдол шинжлэх, уншсан номын шүүмж, хэлэлцүүлэг, кино, контент түшиглэсэн ярилцлага, судалгаа шинжилгээний ажилд дагуулан сургах, мэтгэлцээн, музей хичээл зэрэг нь оюутны суралцахуйг дэмжихэд чиглэж байна. Оюутны төлөөлөлтэй уулзахад тэнхим багш нар хийж бүтээж байгаа оюутныг ямагт

дэмжиж, хөгжүүлж байдгийг онцолж байна. Сургалтын ийм арга зүй сургалтын төлөвлөгөөний бие даалтын цаг өндөр байгаатай мөн нийцэж байна

**Дүгнэлт:** 2.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Баримт нотолгоо:**

- Нэгж хичээлийн хөтөлбөрүүд
- Багш нартай хийсэн уулзалтын тэмдэглэл

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Үнэлгээний даалгаврын арвин сантай болсон. Үнэлгээний нэгдсэн системээс гадна оюутан өөрийгөө болон багш оюутны дүнг хянах дотоод үнэлгээний арга системтэй. Цахим шалгалтын хэлбэр төлөвшиж байгаа.

Сул тал: Оюутны мэдлэг, чадварыг голлон үнэлдэг, хандлагыг үнэлэх арга, шалгуур тодорхой ажиглагдахгүй байна.

**Дүгнэлт:** 2.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

## **ШАЛГУУР 2. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:**

Хөтөлбөрүүдийн сургалтын үйл ажиллагаа нь тогтмолжсон, сургалтын агуулга, хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулж ирсэн, оюутны суралцахуй үйлийг дэмжсэн арга зүй, үнэлгээний арга, шалгууртай хөтөлбөрүүд мөн болохыг онцлон дүгнэв.

**Шинжээчийн дүгнэлт:** “Сургалтын үйл ажиллагаа” шалгуурыг **БҮРЭН ХАНГАСАН** гэж шинжээчид дүгнэлээ.

**Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ ажил олгогч, төгсөгч, суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн хийх. Нэг хөтөлбөрөөр төгсөлт хийж үр дүнг шалгах шаардлагатай.
2. Мэргэжлийн хөтөлбөр хийгээд нэгж хичээлийн хөтөлбөрт оюутны мэдлэг, чадвар, хандлагыг хэрхэн үнэлэх арга, шалгуурыг нарийн зааж өгөх. Үүнд, төгсөгч оюутнуудаас “Суралцагчдад мэдлэг чадвар төлөвшүүлж, тэдгээрийг үнэлэх асуудал тодорхой, боломжтой байна. Гагцхүү хандлага төлөвшүүлэх, хэрхэн хүмүүжүүлэх, түүнийг яаж үнэлэх вэ гэдэг асуудал ойлгомжгүй байдаг” гэж хөндөн ярьж байсныг үндэс болгон хөтөлбөрийн сургалтын арга ажиллагаа, үнэлгээний шалгуурт “Хандлагын үнэлгээ”-г суулгаж өгөх нь хөтөлбөрийн сургалтын хүрэх үр дүнг үнэлэх, төгсөгч-багш нарын ажилд хөтөч, удирдлага болох сайн талтай гэж үзэж байна.

## **Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Баримт нотолгоо:**

- Сургалтын орчны ажиглалт
- Уулзалт, ярилцлага

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Хичээлийн бүх танхим, лабораторид урсгал засвар хийж ширээ сандлыг шинэчилж, сургалт явуулах тохилог орчныг бүрдүүлсэн. Анги танхимуудыг камер, проектор зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Компьютерийн шинэ лаборатори нэмж ашиглалтад оруулсан.

5 давхар шинэ номын санг байгуулж шаардлагатай техник хэрэгсэл, программ хангамж,суудлын тоог нэмэгдүүлснээр номын сангийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж чанар сайжирсан. Давхар бүрт 10 таблет байрлуулсан нь цахим үйлчилгээ ашиглах боломжийг нэмэгдүүлсэн. Номын сан, интернет, оюутны бие даан ажиллах төв болон биеийн тамирын заал нь суралцагчдын бие даан сурах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бололцоог нэмэгдүүлсэн байна.

Нэг оюутанд ногдох хэмжээ нь 1,6м.кв байгаа нь боловсролын байгууллагад тавигдах шаардлагыг хангаж байгаа ба ширээ сандлын хүрэлцээ,хэрэглээ нь стандартад нийцэж байна.

Мультмедиа студийг байгуулж цахим орчин бүрдснээр зайн сургалтын чанар сайжирсан. Цахимаар гадаад болон дотоодын хамтын ажиллагаа, удирдлагын хурал,зөвлөгөөнийг хийх боломжтой зал,танхим хэд хэдийг тохижуулсан нь ажил тасралтгүй шуурхай явах боломжийг нэмэгдүүлсэн. Энэ давуу талаа ашиглан короновирусын өвчлөлийн тархалтаас үүдэн хөл хорио тогтоосон үед онлайн сургалтыг чанартай сайн явуулж чадсан байна. Цахим хичээлийг сүлжээнд тавьснаар оюутнууд боломжтой үедээ орж хэрэгцээт материалаа татан авах боломжтой болсон нь цахимаар явцын болон төгсөлтийн шалгалт авахад хүндрэл гарсангүй.

**Дүгнэлт:** 3.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Баримт нотолгоо:**

- Сургалтын орчны ажиглалт
- Уулзалт, ярилцлага

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Номын сан нь орчин үеийн техник хэрэгслээр хангагдсан бөгөөд 13 фондод 41455 нэрийн 183932 номтой үйл ажиллагаа явуулж байна. Lib4U программ ашигладаг. Уншигч, номын санч, номын фонд гурвыг холбосон уншлага үйлчилгээний мэдээлэл бүрэн автомат болж 18932 номын мэдээлэл цахим хэлбэрт орсон нь багш , суралцагчдад сургалт явуулах боломж, нөхцлийг нэмэгдүүлсэн.

Хичээлийн танхимууд утасгүй интернетээр холбогдсон, ангиуд проектор, зөөврийн компьютерээр хангагдсан нь хичээлийг илүү сонирхолтой, агуулгын хувьд өргөн, чанартай явуулах боломжийг нэмэгдүүлсэн.

Сул тал: шалгалтын үед оюутны хандалт ихсэхээр сүлжээний хурд удааширч, гацах явдал гардаг хүчин чадлыг нь нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн шалгалтын үеэр номын сангийн суудал хүрэлцэхгүй болдог.

**Дүгнэлт:** 3.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Сургалтын орчны ажиглалт
- Уулзалт, ярилцлага
- Өөрийн үнэлгээний тайлан

#### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Шинэ тоног төхөөрөмжөөр тоноглогдож, цахим сүлжээнд холбогдсон, 183932 номын фондтой 5 давхар шинэ номын сан ашиглалтад орсноор хэрэгцээт мэдээлэл, ном, сурах бичгийн хангалтад сайнаар нөлөө үзүүлсэн.

БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар МУБИС,МХТ-ийн дэд бүтцийг шинэчилж, дотоод сүлжээний мэдээлэл дамжуулах хурдыг 1 Gbps болгосноор дата төв, утасгүй интернетийн орчин бүрдэж, хичээлийн байр бүхэлдээ утасгүй интернетийн сүлжээнд холбогдож шинээр сургалтын удирдлага мэдээллийн системийг бий болгосон ба 50 гаруй улсад салбартай SPRINGER олон улсын хэвлэлийн корпорацийн 2000 орчим цахим, ном сэтгүүлийг 2020 он хүртэл ашиглах боломжтой болсон. МУБИС-ийн хэмжээнд 11 цахим санг ашиглаж байгаа ба дижитал ном агуулга бэлтгэх лабораторитай.

Сул тал: Сүүлийн жилүүдэд номын сан барихтай холбогдон шинэ ном худалдан авах төсөв бага зэрэг буурч байсан, одоо ашиглалтад орсон учир нэмэгдэх боломжтой. Гадаад хэлээр байгаа номын ашиглалт буурч байгаад анхаарах хэрэгтэй.

**Дүгнэлт:** 3.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

### **ШАЛГУУР 3. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:**

Сургалтын техник хэрэгслээр боломжийн төвшинд хангагдсан,анги, танхимтай тэдгээр нь сургалтын орчинд тавигддаг эрүүл ахуйн шаардлааг, стандартыг хангасан.

Орчин үеийн техник хэрэгсэл, программ хангамжаар тоноглогдсон 5 давхар шинэ номын сан ашиглалтад орсон нь багш, суралцагчдын сургалт, судалгааны үйл ажиллагаанд маш чухал нөлөө үзүүлсэн. Оюутны бие даан ажиллах үйл ажиллагаа, мэдээлэл олж авах боломж нэмэгдсэн.

Мультимедиа студи, зайн сургалтад ашиглагдах тоног төхөөрөмжүүдээр хангасан нь зайн сургалтыг чанартай сайн явуулах боломжийг нэмэгдүүлсний зэрэгцээ цахимаар сургалт, хурал, зөвлөгөөнийг явуулах боломжийг нэмэгдүүлсэн нь сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баяжуулахад сайн нөлөө үзүүлсэн. Ялангуяа хөл хорио тогтоосон нөхцөлд зайн сургалтын давуу талыг сайн ашигласан төдийгүй сургалт явуулах дадлага, туршлагаа баяжуулсан.

**Шинжээчийн дүгнэлт:** “Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл” шалгуурыг **БҮРЭН ХАНГАСАН** гэж шинжээчид дүгнэлээ.

#### **Зөвлөмж:**

1. Сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар байнга анхаарч байх
2. Гадаад номын хэрэглээг нэмэгдүүлэх боломжийг эрж хайх, эрдэмтэн багш нараар гадаад номыг хэрхэн уншиж ашиглах талаар лекц уншуулж, зөвлөгөө өгүүлэх

## Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

*Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.*

#### Баримт нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, хурлын тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой төлөвлөгөө, тайлан

#### Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Багш бүр 3 жилээр ажлаа төлөвлөж, 4 талт гэрээ байгуулдаг, НУ-ны тэнхим 2016-2018 оны гэрээний дүгнэлтээр тэнхим нь МУБИС-ын хэмжээнд II байр эзэлсэн. 2014-2019 онд МУБИС-ийн 5, МУ-ын 4, олон улсын 4 төсөл, нийт 13 төсөл хэрэгжүүлсэн. ЭЕШ-д 650-750 оноотой элсэгч 70%, 751 онооноос дээшхи нь 100%-ийн тэтгэлэгт хамрагдсан.

Хичээлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэхдээ 4 шатны хороогоор хэлэлцэж үнэлгээ, дүгнэлт гаргадаг байна.

Сул тал: Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнд оюутны оролцоо бага байгаа нь анзаарагдсан.

**Дүгнэлт:** 4.1 Багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөг удирдлагын түвшинд хэлэлцэж баталдаг нь сургалтын чанарыг сайжруулахад чухал нөлөөтэй юм. Энэ давуу талыг үндэслэн шаардлагыг *бүрэн хангасан* гэж дүгнэлээ.

### 4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### Баримт нотолгоо:

- Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний цуврал сэтгүүл, ном бүтээлүүд
- Сүүлийн үед хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төслийн мэдээ, тайлан
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа

#### Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Түүхийн олимпиадыг 2016-2017 оноос багш, сурагчдын дунд 3 удаа явуулсан, хилийн чанадад төрж өссөн хүүхдүүдийн дунд “Эх түүхийн олимпиад” зохион байгуулсан (11-14 насанд 13 улсаас 75 хүүхэд, 15-18 насанд 10 улсаас 57 хүүхэд).

Гадаадын болон дотоодын мэргэжлийн байгууллагуудтай маш сайн хамтран ажилладаг. Ялангуяа БНХАУ-ын Өвөр монгол, ОХУ-ын Халимаг, Буриад улсуудтай тогтмол хамтран ажилладаг.

Сул тал: ЕБС-ийн түүх, нийгмийн ухааны багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа орхигдсон байна.

**Дүгнэлт:** 4.2 Гадаадын болон дотоодын мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтарч ажилладаг. Тухайлбал, ЭШХ зохион байгуулах, хамтын бүтээл гаргах, мэргэжлийн цуврал сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлэх, гадаадын багш нартай туршлага солилцож зочин багшаар ажиллах,

магистрантур, докторантурын хөтөлбөртөө гадаадын оюутнуудыг суралцуулж байгаа явдал нь уламжлал болсон зэргийг харгалзаж үзээд шаардлагыг *бүрэн хангасан* гэж үзэж байна.

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Баримт нотолгоо:**

- Хөтөлбөрийн санхүүжилтийн зардлыг тэнхмийн шаардлагаар зарцуулж байсан баримт

#### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: 2014 оноос бүрэлдэхүүн сургуулийг орлогын бие даасан данстай болгосон (НХУС нь 2017 онд 5,9 тэрбум орлоготой 4,4 тэрбум зарлагатай, 2018-2019 онд Түүхийн тэнхим 54,670.100 төгрөгийн ашигтай), 2011-2017 онуудад багш, ажилчдын цалин 45% өссөн.

7 багш гадаадын 3, суурь судалгааны 3, захиалгат 3 төсөлд, МУБИС-ийн санхүүжилттэй 3, НХУС-ийн санхүүжилттэй 4, нийт 16 төсөлд оролцож байна.

Түүх, багшийн хөтөлбөрийн санхүүжилтийн зардлыг тэнхмийн шаардлагаар (багш нар олон улсын ЭШХ-д оролцоход, ном бүтээлээ хэвлэхэд) зарцуулж байгаа нь сайшаалтай.

Сул тал: Багш, нийгмийн ухааны боловсролын хөтөлбөр нь нийт сургууль даяар хэрэгжиж байгаа ч бие даасан бодлогыг хэрэгжүүлээгүй.

**Дүгнэлт:** 4.3 Багш мэргэжлээр сурч байгаа оюутнуудын ихэнх нь 70-100% засгийн газрын тэтгэлэгт хамрагддаг, монголын түүх ба нийгмийн ухааны хичээлүүд нь ерөнхий эрдмийн хичээлд тооцогдож МУБИС-ийн нийт оюутнууд судалдаг учраас хөтөлбөрийн санхүүжилтын эх үүсвэр найдвартай гэж үзээд шаардлагыг *бүрэн хангасан* гэж дүгнэж байна.

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Баримт нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хийсэн ажил, арга хэмжээний тайлан

#### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: МУБИС-ийг Түүх, Нийгмийн ухааны багш мэргэжлээр төгссөн төгсөгчидтэйгээ холбоо харилцаа сайтай. Төгсөгчид нь эргээд сургуультайгаа холбоотой байж дараа дараагийн төгсөгчидөө ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл эргэх холбоо сайтай юм байна.

Сул тал: Багшийн мэргэжлээр сурч байгаа оюутнуудыг 100% төгсгөж чаддаггүй. Шалтгаан нь элсэн суралцагчид нь хөнгөлттэй болзлоор элсчихээд багшийн мэргэжлээр суралцах сонирхолгүй эсвэл мэргэжлээ солих хандлагатай байна.

**Дүгнэлт:** 4.4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааны давуу талууд дээр үндэслэн шаардлагыг *бүрэн хангасан* гэж үзэж байна.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Баримт нотолгоо:**

- Багш нарийн бичиж нийтлүүлсэн ном, өгүүлэл болон эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлүүд
- Хичээлийн хөтөлбөрүүд цахим хэлбэрт шилжсэн.

### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Оюутнууд хичээлийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сургалтанд ашиглах материал, ном, сургуулийн байршил зэргийг онлайнаар мэдэх бүрэн боломжтой болсон.

Сул тал: Тайланд өгүүлэхдээ санхүүжилтийн талаар МУБИС-ийнхаа талаар л дурдсан байна. Харин Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, тухайн хөтөлбөрүүдийн нээлттэй байдал тодорхой биш байна.

**Дүгнэлт:** Дээрх сул талд үндэслэн 4.5 шаардлагыг хэсэгчлэн хангасан гэж үндэслэв.

### **ШАЛГУУР 4. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:**

Төгсөгчдийн холбоо байгуулагдан хамтран ажиллах болсон нь сургууль төгсөгчдийн эргэх холбоо сайжирсан, хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээнд багш, оюутан оролцоо нэмэгдсэн, гадаад улсад сургалт семинар, олон улсын хурал, туршлага солилцох хамтын ажиллагаа өргөжсөн байна.

**Шинжээчийн дүгнэлт:** Дээрх давуу талуудыг харгалзан үзээд “Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт” шалгуурыг **БҮРЭН ХАНГАСАН** гэж шинжээчид дүгнэлээ.

### **Зөвлөмж:**

- Оюутнуудаас хичээлийн хөтөлбөртэй холбоотой санал авдаг ч ажил хэрэг болгох нь учир дутагдалтай байна. Иймд оюутнуудын санал, хүсэлтийг тэнхимээрээ хэлэлцэж хичээлийн хөтөлбөртөө тусгаж байх

### **Шалгуур 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.**

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

### **Баримт нотолгоо:**

- Оюутны гарын авлага
- Сургалтын журам
- Диплом, түүний хавсралт

### **Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо харьцангуй өндөр учраас цаашид сайн суралцагч байх боломжтой. БТБ хөтөлбөрөөр элсэн суралцагчдын дундаж оноо 595.6, БНУБ хөтөлбөрийн элсэгчид 616.4 дундаж оноотой байгаа нь оюутнуудын сургалтын чанарын суурь үзүүлэлт болно гэж үзэв. Суралцагчдад “тэтгэлэгтэй багшлах дадлага”, “650-аас дээш оноотой элсэгчдэд сургалтын төлбөрийн 70-100 хувийн тэтгэлэг”, “НХУС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг” (Үндэсний ба ОУ-ын уралдаан тэмцээнд амжилттай оролцсон оюутанд), 4 улирал дараалан 3.7-оос дээш голчтой оюутанд олгодог тэтгэлэг” (2-4 кредитийн тэтгэлэг) зэрэг тухайн сургуульд суралцагчдад л олгодог хөнгөлөлт, тэтгэлгүүд нь сайн элсэгч татахад нөлөөлсөн.

Шинээр элсэгчдэд зөвлөн чиглүүлэх ажиллагаа төлөвшиж тогтмолжсон. Тухайлбал: шинээр элсэгчдэд зориулсан “Оюутны гарын авлага”-ыг хэвлэн түгээдэг, хөдөлмөр эрхлэх, цагийн ажлын мэдээллээр хангаж зуучилдаг, тэтгэлэг, хөнгөлөлтүүд, түүнд хэрхэн хамрагдах, болзол шаардлагыг мэдээлэх, материал бүрдүүлэх, эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх,



оюутан оюутандаа туслах “Оюутан багш”-ийн сургалт явуулах, лекц сургалт зохион байгуулах, Оюутны холбоо, клубүүдийн үйл ажиллагааг дэмжих зэргээр оюутны хөгжил төлөвшлийг дэмждэг нь тайлан болон оюутан, багш, төгсөгчдийн уулзалтаас тодорхой харагдаж байна.

**Дүгнэлт:** 5.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Баримт нотолгоо:**

- Багш, оюутантай уулзсан тэмдэглэл
- Өөрийн үнэлгээний тайлан

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Зөвлөх багшийн үүрэг өндөр, оюутныг сайн чиглүүлдэг. Зөвлөх багш нар шинээр элсэгчдийг бүртгэх, хичээл сонголтын зөвлөгөө өгөх, хамтран сонгох, сонголтыг баталгаажуулах, оюутны мэдээллийг мэдээллийн системд оруулах, оюутны байрны мэдээллээр хангах, өргөдлийг хүлээн авах, хуваарилалт хийх, улирал бүрийн хичээлийн үнэлгээнд анализ хийж танилцуулах, хичээл тасалсан, сурлагаар хоцрогдсон оюутны ар гэртэй холбогдох, оюутны сурдаг эсэх, дүнгийн, голч онооны тодорхойлолтыг цахим машинаар хэрхэн авахад зааварчлах, тэтгэлэг, хөнгөлөлтийн мэдээллийг хүргэх, болзол хангасан тохиолдолд тодорхойлолт гаргах, материалыг Хөтөлбөрийн Нэгдсэн алба, сургуулийн захиралд хүргүүлэх, “Чийрэг оюутан” хөтөлбөрийн хүрээнд бүх оюутныг эмчийн үзлэгт жил бүр хамруулах, мэдээллээр тогтмол хангах зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэдэг байна. Зөвлөх багшийн ажлыг “Бүтээлч цаг”-ийн 1 кредитээр үнэлж байна.

Оюутны эрдэм шинжилгээний хурал тогтмолжсон, бусад улс, байгууллага, сургуулиас зохиож буй хуралд идэвхтэй, амжилттай оролцдог. Түүхийн тэнхимээс Буриадын ИС, Хөххотын Багшийн Их сургуультай хамтран жил бүр Оюутны эрдэм шинжилгээний хурлыг ээлжээр зохион байгуулж, 7-10 оюутан тогтмол оролцдог, “Адууны соёл”, “Түүхийн хүрд” их дээд сургуулийн оюутны дунд зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хурал зохион байгуулан оролцож байна. НУТэнхимээс “Судлаач оюутан” Эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулдаг. Нийт хурал, тэмцээн уралдаанд жил бүр 1-6 оюутан тогтмол байр эзэлсэн үзүүлэлттэй байгаа нь оюутны оролцоо, түүний чанарыг тодорхойлох гол үзүүлэлт байна.

**Дүгнэлт:** 5.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Баримт нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Оюутны хөгжлийг дэмжих жилийн тайлан

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Оюутны өөрөө удирдах байгууллагад мөнгө төсөвлөдөг. 2018 онд 2.5 сая, 2019 онд 5 сая байжээ. Лекц уулзалт тогтмол зохион байгуулж, оюутны хөгжлийг дэмждэг. Түүхийн тэнхимээс “Монгол бахархлын өдөр”, “Дээлтэй Монгол” хөтөлбөр, НУТэнхимээс “Судлаачийн цаг” цуврал лекц, “Судлаач оюутан” Эрдэм шинжилгээний хурлыг тогтмол зохион байгуулдаг. “Жендер”, “Эйдос”, “Фемида”, “Бүтээлч сэтгэлгээ”, “Марко Поло” зэрэг мэргэжлийн клубүүд,

“Шинэ оюутан”, “Чийрэг оюутан”, “Орлоготой оюутан”, “Авьяаслаг оюутан”, “Санаачилгатай оюутан” зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлэн оюутны хөгжил төлөвшлийн төлөө ажиллаж байна.

**Дүгнэлт:** 5.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Баримт нотолгоо:**

- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- Багш нарын уулзалтын тэмдэглэл

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, дүн дүйцүүлэх арга ажиллагааг журамласан. ЭЕШ-ын чиглэл тохирч байх, дүйцүүлэх нийт кредит 15-аас ихгүй байх, төгсөх ангид болон магадлан итгэмжлэгдээгүй их дээд сургуулиас шилжүүлэн суралцуулахгүй байх, анх элссэн хөтөлбөрөөрөө нэг улирал, түүнээс дээш хугацаагаар суралцсан байх, үнэлгээний голч 2.3-аас дээш байх, Хичээл сонголт-2 \Мэргэжлийн хичээл\ хийснээс хойш шилжилт хөдөлгөөн хийхийг хориглохоор “Сургалтын журам”д заасан. Дүнг өмнөх дүнгийн тодорхойлолтоор болон “шууд шалгалт”-аар дүйцүүлэх 2 хэлбэрийг тусгасан байна.

Шилжилт хөдөлгөөний судалгааг сайн хийсэн. Тухайлбал: БТБ хөтөлбөрөөр суралцагчдаас тайлангийн хугацаанд 78 оюутан жилийн чөлөө авснаас 62 нь ар гэрийн шалтгаанаас, 50 оюутан сургуулиас гарсны 32 нь ар гэрийн шалтгаанаас \ихэвчлэн төлбөр төлж чадахгүй болсноос гэж багш нарын уулзалт дээр ярьсан\ болсон. БНУБ хөтөлбөрөөр суралцагчдаас 259 шилжилт хөдөлгөөн хийсний 22 нь бусад сургуулиас ирсэн байхад 14 оюутан бусад сургуульд шилжсэн байна. Шилжсэн оюутны ихэнх нь тэс өөр мэргэжлийн чиглэлээр суралцаж байгаа нь элсэгчдийн мэргэжил сонголт оновчгүй болж байгааг илтгэж байна гэж багш нар ярьж байна. Мөн 122 оюутанд нийт 1559 кредитийг дүйцүүлэн тооцож, шилжилт хөдөлгөөнийг оюутанд ээлтэй байдлаар зохион байгуулжээ.

**Дүгнэлт:** 5.4 шаардлагыг бүрэн хангасан байна.

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Баримт нотолгоо:**

- Бакалаврын диплом, дипломын хавсралт

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Баримт бичгийн загвар хэлбэршиж, шинэчлэгдэн батлагдсан. Дипломыг монгол кирилл, англи, үндэсний монгол бичгээр үйлдэх бөгөөд Дипломын хавсралтад Сургуулийн хэвшил, Мэргэжлийн зэрэг: зэрэг, суралцсан хугацаа, элсэгчдэд тавигдах шаардлага, Хөтөлбөрийн агуулга: суралцах хэлбэр, хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн кредитийн задаргаа, үнэлгээний хэлбэр, голч дүн, Төгсөлтийн дараах шат: цаашид ахисан түвшинд сурах боломж, Нэмэлт мэдээлэл: магадлан итгэмжлэл, нэмэлт мэдээлэл авах эх үүсвэр, Дээд боловсролын тогтолцоо: байгууллагын төрөл, хөтөлбөрийн төрөл болон зэрэг олгох, сургалтын зохион байгуулалт ба бүтэц, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, баталгаажилт, үргэлжилсэн сургалт, дээд боловсрол эзэмших боломж, үндэсний хэмжээний мэдээлэл авах эх сурвалж зэргийг багтааж, Олон Улсын жишигт нийцсэн, хүлээн зөвшөөрөгдөхүйц, төгсөгч оюутан цаашид ахисан түвшинд суралцахад мэдээлэл боломжоор хангахад чиглэсэн хөтөч эх сурвалжийн шинжтэй болж чаджээ.

**Дүгнэлт:** 5.5 шаардлагыг бүрэн хангасан байна.

## ШАЛГУУР 5. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа бүхэлдээ оюутанд ээлтэй, тэднийг сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжих чиглэлтэй болж төлөвшсөн байна.

**Шинжээчийн дүгнэлт:** “Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН гэж шинжээчид дүгнэлээ.

## Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.**

### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### Баримт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшлах бүрэлдэхүүнтэй холбоотой баримт материалууд

#### Шинжээчийн үнэлгээ:

**Давуу тал:** Багш, түүхийн боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нийт 17 багшийн 80 гаруй хувь нь эрдмийн зэрэг цолтой байгаа нь хөтөлбөр хэрэгжихэд давуу сайн талтай. Мөн төрөөс сайн багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь түүхийн багш хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайнаар нөлөөлж байна.

Багш, нийгмийн ухааны боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нийт 13 багшийн 50 гаруй хувь нь эрдмийн зэрэг цолтой байгаа нь сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн өндөр түвшинд шаардлагын хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой. Эрдмийн зэрэг хамгаалж байгаа багш нарын цагийн ачааллыг зохицуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна гадаадын их, дээд сургуулиудад мэргэжил дээшлүүлэх, зочин судлаач, зочин профессороор уригдан ажиллахад нь ажлын байрыг нь хадгалж байгаа нь багшийн хөгжилд бодит дэмжлэг болж чадвартай сайн багш нарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлж байна.

Эрдмийн зэрэг цолтой багш нарын тоо тасралтгүй нэмэгдэж, арга зүйн ур чадвартай, туршлагатай багшлах боловсон хүчний нөөц, хангамж хангалттай сайн бүрдсэн байна.

**Сул тал:** Тайланд багш, нийгмийн ухааны боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа залуу багш нар хэдэн оноос докторантурт суралцаж байгаа нь тодорхойгүй.

**Дүгнэлт:** 6.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

### 6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### Баримт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшлах бүрэлдэхүүнтэй холбоотой баримт материалууд

#### Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: МУБИС-ийн Ректорын 2018 оны 10 сарын 10-ны өдрийн А/249 тоот тушаалаар батлагдсан Багшийн хөгжлийн хөтөлбөрийг удирдлага болгон өөрийн НХУИС-ийн онцлогийг тусгасан хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Түүхийн болон нийгмийн ухааны багшийн хос мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь багш нарын ажлын уялдаа холбоо, арга зүй, ур чадвар хөгжихөд сайнаар нөлөөлж байгаа төдийгүй, төгсөгчдөд ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлж байна.

Хос мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд хичээлийн агуулгын давхцал, дадлагын ажлын тоо олон, (нийт 4 удаа), энэ нь мэргэжлийн хичээлийн цаг багасахад нөлөөлж байгаа төдийгүй, зарим дадлага хичээлийн үед хийгдэж нааш, цааш олон удаа явах нь суралцагчдад чирэгдэл учруулж байгаа, ялангуяа суралцах хугацаа 4,5 жил байгаа нь цаг хугацаа, санхүүгийн хувьд дарамттай байгаа тухай багш, суралцагчид, төгсөгчидтэй хийсэн уулзалт дээр дурдагдаж байсан. Энэ дарамтыг хичээлийн давхцлыг арилгах, дадлага, мэргэжлийн хичээлийн харьцааг оновчтой болгох замаар шийдвэрлэх боломжтой.

**Дүгнэлт:** 6.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Баримт нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшлах бүрэлдэхүүнтэй холбоотой баримт материалууд

**Шинжээчийн үнэлгээ**

Давуу тал: Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төсөв нэмэгдэж, жил бүр шилдэг бүтээлийг шалгаруулж урамшуулдаг. Жилээс жилд багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн тоо өсч, гадаадын нэр хүндтэй сэтгүүлүүдэд бүтээлээ хэвлүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хуралд уригдан илтгэл тавьж, гадаад, дотоодын магистр, докторуудын дипломын ажлын удирдагч, шүүмжлэгчээр ажиллаж байгаа нь багшийн хөгжлийг дэмж хөтөлбөр үр дүнтэй сайн хэрэгжиж байгаагийн илрэл гэж үзэж болно.

2014-2019 онд гадаадын 3 төсөл, суурь судалгааны 3, захиалгат 3 төсөлд, МУБИС-ийн санхүүжилттэй 3, НХУС-ийн санхүүжилттэй 4, нийт 16 төсөлд оролцож байгаа нь багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох оролцоо сайн байгааг харуулж байна. Багш нар ХБНГУ, БНХАУ, Япон, АНУ, Итали зэрэг өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлэх, зочин судлаач, зочин профессороор уригдан ажилласан (давхардсан тоогоор 17 багш) болон хамтын ажиллагаатай их, дээд сургуулиуд болон захиалгат төслүүд, цөм хөтөлбөр боловсруулах, сурах бичиг зохиох зэрэг ажлуудад багш нар идэвхитэй оролцсноор багшийн мэдлэг чадвар, арга барил өсч хөтөлбөр хэрэгжихэд эерэг нөлөө үзүүлж байна.

**Дүгнэлт:** 6.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Баримт нотолгоо:**

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшлах бүрэлдэхүүнтэй холбоотой баримт материалууд

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: МУБИС-ийн Чанарын баталгаажуулал, мониторингийн албанаас НХУС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, багшийн ахиц дэвшил, ур чадвар, багшид тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг оюутан, багш, удирдах ажилтан, бусад сонирхлын бүлгийн оролцоотойгоор үнэлж дүгнэлт гаргадаг нь багш үйл ажиллагаандаа дүгнэлт хийж цаашид ахиц дэвшихэд сайнаар нөлөөлж байна. Тайлангийн хугацаанд багш нарын авсан үнэлгээ нь 80-аас дээш хувьтай байгаа нь үүнийг гэрчилж байна.

Багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан хичээлийн жилд 2 удаа үр дүнгийн нэмэгдэл олгож, мөн МУБИС-ийн “Захирлын нэрэмжит шагнал” оны шилдэг багш”-ийг шалгаруулж урамшуулж байгаа нь багшийн судалгааны ажлын тоо, чанарт сайнаар нөлөөлсөн.

Түүхийн тэнхмийн багш С.Энхжин 2018 онд МУБИС-ийн шилдэг нэг сэдэвт бүтээлийн дэд байр, Нийгмийн ухааны тэнхим сургуулийн хэмжээнд II байрт шалгарч 3 сая төгрөгний мөнгөн урамшуулал хүртсэн зэрэг бодит үнэлгээ, урамшуулал нь багш нарт ажиллах урам өгч хөтөлбөр сайнаар хэрэгжих хөшүүрэг болсон.

**Дүгнэлт:** 6.4 шаардлагыг бүрэн хангасан байна.

**ШАЛГУУР 6. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:** Нэг багшид 10 окутан оногдож ажлын ачаалал тэнцвэртэй байгаа нь судалгааны ажил хийх боломжийг нэмэгдүүлсэн. Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн тоо нэмэгдэж, чанарт ахиц гарсан. Гадаадын их дээд сургуулиудад зочин судлаач, зочин профессороор уригдан ажиллаж, бүтээлүүд нь гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлэгдэж байгаа нь багш нарын судалгааны ажлын төвшин шаардлага хангаж хөтөлбөр хэрэгжүүлэхэд сайн нөлөө үзүүлж байна. Энэ нь окутны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох оролцоог нэмэгдүүлж, чанарыг сайжруулахад нөлөө үзүүлсэн.

МУБИС-ийн захиргаанаас шилдэг тэнхим, шилдэг бүтээл, шилдэг багш шалгаруулж, багш нарт үр дүнгийн нэмэгдэл олгож байгаад багш нар сэтгэл ханамжтай. Уг шалгаруулалтад багш нар бүх боломжоо дайчлан оролцдог.

**Шинжээчийн дүгнэлт:** “Багшийн үйл ажиллагаа” шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН гэж шинжээчид дүгнэлээ.

**Зөвлөмж:** Импакт фактор өндөртэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх

## Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

**Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.**

### 7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

**Баримт нотолгоо:**

- Чанарын баталгаажуулалтын баримт бичгүүд

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: Багш нар олон улсын хамтарсан, суурь судалгааны, захиалгат, МУБИС-ийн ба НХУС-ийн санхүүжилттэй эрдэм шинжилгээ, судалгааны төслүүдэд хамрагддаг. Дотоод хяналт, үнэлгээний оновчтой механизмыг бүрдүүлэх зорилгоор 2014 оноос “Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба”, 2017 оноос “Хяналт, үнэлгээний алба” байгуулж ажиллаж байна.

Сул тал: Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хийх нэгдсэн аргачлал, арга зүй тодорхойгүй байна.

**Дүгнэлт:** Хөтөлбөрийн дотоод баталгаажуулалтын төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд шалгуур үзүүлэлт бүрэн бус, хяналт үнэлгээний чиглэлээр ажиллах мэргэжилтэнг мэргэшүүлэх шаардлагатай гэж үзээд 7.1 шаардлагыг хэсэгчлэн хангасан гэж дүгнэлээ.

### 7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

**Баримт нотолгоо:**

- Оюутны хөгжлийг дэмжих жилийн тайлан
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн тухай тайлан
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа

**Шинжээчийн үнэлгээ:**

Давуу тал: 1 диплом 2 хавсралт буюу хавсарсан мэргэжлээр төгсгөж байгаа нь сайшаалтай. Төгсөгч нарын заах арга зүй сайн байдаг.

Сул тал: Төгсөгч нарын заах ур чадвар сайн байгаа ч онолын мэдлэгийг эзэмшүүлэх, судлах цаг нь бага байна.

**Дүгнэлт:** Төгсөгчид сургуультайгаа эргэх холбоо сайтай, дараа дараагийн төгсөгчидөө ажлын байранд татан оруулах, туслалцаа үзүүлэх эерэг нөлөөтэй зэргийг харгалзан үзээд 7.2 шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэлээ.

**ШАЛГУУР 7. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:**

Хөтөлбөрийн дотоод баталгаажуулалтын төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн төлөвлөлт тодорхойгүй, чанарыг сайжруулах аргачлал, арга зүй, хууль эрх зүйн зохицуулалт тодорхой бус байна.

**Шинжээчийн дүгнэлт:** Дээрх шаардлага, сул талуудад үндэслэн “Чанарын үнэлгээ, баталгаажилт” шалгуурыг ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН гэж шинжээчид дүгнэлээ.

**Зөвлөмж:**

- ЕБС-д заагдаж байгаа “Иргэний боловсрол”, “Ёс зүй” гэсэн хичээлүүдийн агуулга шаардлага хангахгүй байгаад МУБИС энэ тал дээр идэвх оролцоотой ажиллах шаардлагатай байна.

**Шаардлага:**

- Хөтөлбөрийн үр дүн, үнэ цэнийг үнэлэх аргачлал, арга зүйгээ тодорхой болгох нэн шаардлагатай.

## ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан шаардлага (2)	Хэсэгчлэн хангасан шаардлага (1)	Хангаагүй шаардлага (0)	Дүгнэлт
1-А	Багш, нийгмийн ухааны боловсролын хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2, 1.3			Бүрэн хангасан
1-Б	Багш, түүхийн боловсролын хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2, 1.3			Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	2.1, 2.2, 2.3			Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.1, 3.2, 3.3			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.1, 4.2, 4.3, 4.4	4.5		Бүрэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	6.1, 6.2, 6.3, 6.4			Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	7.2, 7.3	7.1		Хэсэгчлэн хангасан
<b>Нэгдсэн дүгнэлт</b>		<b>БҮРЭН ХАНГАСАН</b>			

Өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримт, уулзалт ярилцлагын тэмдэглэлд үндэслэн шинжээчийн баг “Багш, нийгмийн ухааны боловсролын”, “Багш, түүхийн боловсролын” бакалаврын хөтөлбөр нь БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, чанарыг цаашид сайжруулах чиглэлээр дараах шаардлага/зөвлөмжийг өгч, шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

### ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨМЖ

Шалгуур 1-А: “Багш, нийгмийн ухааны боловсрол” хөтөлбөрийн төлөвлөлт

1. Хичээлийн хөтөлбөртэй холбоотой засаж сайжруулах зүйлсийг (тухайлбал хөтөлбөрийн тогтвортой байдал, алсын хараа) анхаарч, цаашид хэрэгжүүлэх
2. Хичээлийн хөтөлбөрийг зах зээлийн (хэрэглэгчийн) судалгаанд суурилан тэдний хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад тулгуурлан сайжруулахаас гадна ажил олгогч мэргэжилтнээс юуг, ямар чадварыг шаардаж байгааг олж илрүүлэн хөтөлбөртөө тусгах
3. Багшлах талын хичээлүүдийг интеграцлах, мэргэжлийн онолын хичээлүүдийн цагийг нэмэгдүүлэх
4. Боловсрол судлал, сэтгэл судлалын хичээлүүдийн давхцал маш их байдгийг төгсөгчид, суралцагсад ярьж байсныг хичээлийн хөтөлбөртөө тусгах

Шалгуур 1-Б: “Багш, түүхийн боловсрол” хөтөлбөрийн төлөвлөлт

5. Хөтөлбөрийн хорооны хэлэлцүүлэгт ажил олгогч, төгсөгчдийг оролцуулахыг ажил хэрэг болгох

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

6. Хөтөлбөрийн шинэчлэлийг хийхдээ ажил олгогч, төгсөгч, суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн хийх
7. Мэргэжлийн хөтөлбөр хийгээд нэгж хичээлийн хөтөлбөрт оюутны мэдлэг, чадвар, хандлагыг хэрхэн үнэлэх арга, шалгуурыг нарийн зааж өгөх.

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

8. Сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар байнга анхаарч байх
9. Гадаад номын хэрэглээг нэмэгдүүлэх боломжийг эрж хайх, эрдэмтэн багш нараар гадаад номыг хэрхэн уншиж ашиглах талаар лекц уншуулж, зөвлөгөө өгүүлэх

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

10. Оюутнуудаас хичээлийн хөтөлбөртэй холбоотой санал авдаг ч ажил хэрэг болгох нь учир дутагдалтай байна. Иймд оюутнуудын санал, хүсэлтийг тэнхимээрээ хэлэлцэж хичээлийн хөтөлбөртөө тусгаж байх

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

11. Импакт фактор өндөртэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

12. ЕБС-д заагдаж байгаа “Иргэний боловсрол”, “Ёс зүй” гэсэн хичээлүүдийн агуулга шаардлага хангахгүй байгаад МУБИС энэ тал дээр идэвх оролцоотой ажиллах

## **ШИНЖЭЭЧИЙН ШААРДЛАГА**

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

1. Хөтөлбөрийн үр дүн, үнэ цэнийг үнэлэх аргачлал, арга зүйгээ тодорхой болгох

Шинжээчийн багийн ахлагч	.....	Ш.ГАНХУЯГ
Шинжээчийн багийн гишүүн	.....	С.ЦОЛМОН
Шинжээчийн багийн гишүүн	.....	Г.ЖАРГАЛСАЙХАН



#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Багшийн нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Майл хаяг
1	Ж.Отгонбаяр	багш	Философи	99285102	khuldjo@msue.edu.mn
2	Б.Өлзийсайхан	багш	Философи	86886888	saikhana88@gmail.com
3	Э.Чулуунцэцэг	багш	Эрх зүй	88096042	e_chuluuntsetseg@yahoo.com
4	С.Түмэндэлгэр	багш	Социологи	99089764	tumeesen@gmail.com
5	Л.Сарангэрэл	багш	Социологи, улс төр	99050351	lsarangerel_11@yahoo.com
6	Б.Батзаяа	багш	НУ-сургалтын арга зүй	91888444	bat.zayanaa88@gmail.com
7	М.Саранцэцэг	багш	Соёл,шашин	99137618	saraa_myunga@yahoo.com
8	О.Өнөрцэцэг	багш	Эрх зүй	88833897	unur_1206@yahoo.com
9	Э.Гэрэлд-Од	багш	Улс төр	99990098	

##### II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс, түвшин	Сонгосон байдал	Утас	Майл хаяг
1.	В.Нямдолгор	4	Орон нутгийн	98240441	<a href="mailto:Vnyamka80@gmail.com">Vnyamka80@gmail.com</a>
3	Н.Хүслэн	3	клубын гишүүн	91217493	<a href="mailto:a.khuslen0119@gmail.com">a.khuslen0119@gmail.com</a>
4	Н.Бүжинлхам	2	Оюутан	89894138	<a href="mailto:Mebujka11@gmail.com">Mebujka11@gmail.com</a>
5	Ө.Чинбаяр	1	Оюутан	98601012	<a href="mailto:Chinbayr7@yahoo.com">Chinbayr7@yahoo.com</a>
			Хөгжлийн бэрхшээлтэй		НУБ ангид байхгүй

##### III. Ажил олгогчдын нэрс

№	Ажил олгогчийн нэр	Байгууллага, албан тушаал	Утас	Майл хаяг
1	А.Дулмаа	БЗД, 85-р сургуулийн захирал	99087729	<a href="mailto:mailto:duka@yahoo.com">mailto:duka@yahoo.com</a>
2	У.Ундармаа	ХУД, 41-р сургуулийн захирал	88023458	<a href="mailto:undraaUndarmaa11@gmail.com">undraaUndarmaa11@gmail.com</a>

##### IV. Төгсөгчдийн нэрс

№	Төгсөгчийн нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	утас	Майл хаяг
1	Б.Батням	2013	Манлайллын боловсролын төвд захирал	99905064	mbut.batnyam@yahoo.com
2	Б. Гантулга	2014	Номт наран сургуульд багш	99695992	gantulga@naran.edu.mn
3	Н.Мандуул	2003	Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт	88092176	natsag.manduul@gmail.com

4	Б.Мөнгөншагай	2010	БГД мэргэжилтэн	99123446	Mungunshagai099gmail.com
---	---------------	------	-----------------	----------	--------------------------

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

МУБИС-ийн НХУС-ийн захирлын 2020.10.06-ны 1/236 дугаар албан тоот

Шинжээчийн багийн дүгнэлтэд хариу хүргүүлэх тухай

МУБИС-ийн “Багш, нийгмийн ухааны боловсрол” D011403 бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхээр тус хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан болоо хавсралтыг илгээсний дагуу танай шинжээчид тус сургуульд 2020 оны 6-р сарын 2-5-ны өдрүүдэд ажиллаж, хөтөлбөр хэрэгжүүлэгч багш, оюутан, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөлтэй уулзаж, сургалтын орчин, анги танхим, номын сан зэрэгтэй танилцсан билээ.

Ийнхүү БМИҮЗ-өөс томилсон “Багш, нийгмийн ухааны боловсрол” хөтөлбөрийг магадлах шинжээчдийн багийн үнэлгээний тайлантай танилцаж дараах хариуг хүргүүлж байна.

Шинжээчийн баг ажлын тайлангаа 2020 оны 10-р сарын 01-нд бидэнд ирүүлсэн бөгөөд тус тайлангийн талаар бидэнд тусгайлан хэлэх санал үгүй, шинжээчдийн зөвлөмж, саналыг бүрэн хүлээн зөвшөөрч, хөтөлбөрийн хөгжил, хэрэгжүүлэлтээ анхааран ажиллахыг уламжилж байна.

Бид та бүхэнтэй хамтран ажилласандаа баяртай байгаа бөгөөд цаашид бидний хамтын ажиллагаа улам өргөжинө гэдэгт итгэлтэй байна.

Захирал

профессор Ж.Батбаатар

Түүхийн тэнхимийн эрхлэгч

профессор Ж.Гэрэлбадрах

Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч

профессор Т.Нэмэхжаргал

## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага, зөвлөмж

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага, зөвлөмж